



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 1/94

Мөрөн сум

Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал амьтны эруул мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 17.3, 19-20 дугаар зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүрээт багийн нутаг "Бага Чандмань" гэх газарт нутаглаж буй Г.Хосбаярын суурьт гоц халдварт хонь ямааны цэцэг өвчин оношлогдсонтой холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны 04 дугаар сарын 29-ний А/68 дугаартай захирамжийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч хэрэгжуулэн ажилласны үр дүнд дахин өвчлөл илрээгүй тул хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Мэдрэмтгий малд байнгын үзлэг, тандалт халдваргуйтгэлийн арга хэмжээг шат дараатай зохион байгуулж ажиллахыг "ЗОН ДЭМ" ХХК МЭҮН-д өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд мал эмнэлгийн байгууллагад цаг алдалгүй мэдэгдэхийг малчдад үүрэг болгосугай.

3. Хязгаарлалтын дэглэмийг цуцалсантай холбогдуулан холбогдох бусад арга хэмжээг авч ажиллахыг Засаг даргын орлогч дарга (Б.Мягмаржав)- д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.БАТЦООЖ